

А Хүн ам зүй, боловсрол болон хөдөлмөрийн зах зээлийн тухай тоо баримтууд

I. Германы хүн ам зүйн хөгжил

Манай улсын хүн ам насжиж, олон үндэстнийх болж цөөрсөөр байна.

Герман улс 81,8 сая хүн амтай: Үүний 41,7 сая нь эмэгтэйчүүд, 40,1 сая нь эрэгтэйчүүд юм. 81,8 сая хүн амын ойролцоогоор 14 сая буюу 19,6% нь цагаач буюу бусад үндэстний гаралтай, үүнээс 6,7 сая нь гадаадынхан, өөрөөр хэлбэл германы паспортгүй иргэд оршин сууж байна. Гадаад иргэдийн 24,8 хувь нь турк, 7,7 хувь нь итали, 6,8 хувь нь серб, монтенегро, косово, 6 хувь нь польш, 4,2 хувь нь грек, 17,5 хувь нь Европын Холбооны гишүүн орнуудаас 29,8 хувь нь өөр бусад орны иргэд ажээ.

Эмэгтэйчүүдийн дундаж наслалт 82,4 байхад эрэгтэйчүүдийн дундаж наслалт 77,2 байна. Төрөлтийн дундаж коэффициент нэг эмэгтэйд 1,3 хүүхдээр оногдож, жилдээ нийт 551.330 хүүхэд төрж байна.

81,8 сая хүн амаас:

- 0-6 настай 5%
- 6-15 настай 8%
- 15-25 настай 11%
- 25-45 настай 27%
- 45-65 настай 28%
- 65 ба түүнээс дээш насны 21%

0-оос 15 насны хүүхдүүд 13 хувийг эзэлж байхад, 65-аас дээш насныхан хүн амын 21 хувийг эзэлж байна.

2025 оны төлөв

2025 он гэхэд нийт хүн амын дунд 30-аас доош насныхны эзлэх хувь 16,5% орчим болж буурах хандлагатай байна. Хөдөлмөрийн насныхны эзлэх хувь 10 орчим хувиар буурна. Харин 65 ба түүнээс дээш насныхны эзлэх хувь 21 орчим хувиар өсөх болно.

Гэр бүл болон хамтын амьдралын бусад хэлбэрүүд

Германы 23,8 сая гэр бүлийн 8,4 сая нь 18-аас доош насны хүүхэдтэй, үүнээс 6,13 сая хүүхэд албан ёсоор гэр бүл болсон ээж аавтайгаа, 0,69 сая нь хамтран амьдрагч ээж аавтайгаа амьдардаг бөгөөд 1,4 сая эмэгтэйчүүд ба 0,16 сая эрэгтэйчүүд өрх толгойлон хүүхдүүдээ ганцаараа өсгөж байна.

Ялангуяа хотуудад ганцаараа амьдардаг өрхийн тоо их нэмэгдэж байна. Нийт хүн амын талаас яльгүй илүү хувь нь буюу 51 хувь нь хүүхдүүдтэйгээ хамт амьдарч байна. Зүүн Германы гэр бүлийн зөвхөн 45 хувь нь хүүхдүүдтэйгээ амьдарч байна. Цагаач иргэд герман иргэдтэй харьцуулахад дунджаар илүү олон хүүхэдтэй. Тэд ихэвчлэн залуудаа гэрлэж, албан ёсны гэр бүл зохион амьдардаг.

(Эх сурвалж: Фишерийн 2011 оны дэлхийн цоморлиг ба Германы боловсрол 2010 онд)

II. Боловсрол

3 хүртэлх насны хүүхдийн асаргаа Германд

3 хүртэлх насны 470 000 гаруй хүүхэд цэцэрлэг, ясли болон өдрийн асрагчтай өсч хүмүүжиж байна. Энэ нь 3 хүртэлх насны нийт хүүхдүүдийн дөнгөж 23,0 хувийг хамарч байгаа юм. Хүүхдийн цэцэрлэг, яслид өсч хүмүүжиж буй хүүхдүүдийн 17 хувь нь цагаач гаралтай хүүхдүүд байна.

Баруун Герман улсад нийт хүүхдүүдийн дөнгөж 17,3 хувь нь цэцэрлэг, яслид хамрагдаж байхад хуучин Ардчилсан Герман улсад энэ тоо өнөөгийнхөөс бараг гурав дахин их буюу нийт хүүхдийн 48%-ийг хамарч байсан үе бий. Берлин хотод нийт хүүхдүүдийн 42.1% нь цэцэрдэг, яслид хамрагдаж байлаа.

3 хүртэлх насны хүүхдийн цэцэрлэг яслийн орон тоо Заксен-Анхалтед хамгийн өндөр (55,9 хувь), удаагаар нь Бранденбург (51 хувь) ,Мекленбург-Форпоммерн (50,7 хувь) холбооны улсууд орж байлаа. Баруун Германы нутагт хүүхдийн цэцэрлэг, яслид хамрагдалтын байдлаар Райнланд-Фальц 20,1 хувьтайгаар тэргүүлж Баден-Вюртемберг 18,3 хувьтайгаар удаах байранд орж байлаа.

3-аас 6 хүртэлх насны хүүхдийн цэцэрлэгийн орон тоо

Ойролцоогоор 1,91 сая хүүхэд хүүхдийн бүтэн өдрийн цэцэрлэг ясли эсхүл ээж буюу аавын халамжинд өсч хүмүүжиж байна. Энэ нь герман улсын нийт хүүхдийн 92,2 % - тай тэнцэж байна.

Нийт хүүхдийн 28 хувь нь цагаач гаралтай хүүхдүүд байна.

(Эх сурвалж: хүүхдийн өдрийн асаргаа, хүмүүжлийн байдлыг бүс нутгаар гаргасан судалгаа 2011 онд. Нийтлэгдсэн: Холбоо болон холбооны улсуудын статистикийн мэдээгээр)

Дунд сургууль, мэргэжлийн сургууль, их, дээд сургуулийн байдал

Герман улсын үндсэн хуульд сургуулийн систем нь холбооны улсуудын бүтцийн дагуу зохион байгуулагдана гэж заасан байдаг. Холбоо бус харин холбооны улсууд боловсролын тухай шийдвэрийг гаргах эрхтэй.

2008 оны байдлаар герман улс дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 6,2%-ийг боловсролын салбарт зарцуулсан байна. Энэ нь манай улсын эдийн засгийн чадавхитай харьцуулахад боловсролд оруулж буй хөрөнгө оруулалт нь хангалтгүй үзүүлэлт бөгөөд эдийн засгийн хамтын ажиллагааны орнуудын дунджаас доогуур үзүүлэлттэй байна.

(Эх сурвалж: Германы боловсрол 2010 онд, ССК, ХБСШЯ*)

* Соёлын сайд нарын зөвлөгөөн,
Холбооны боловсрол, судалгаа, шинжилгээний яам - орчуулагч

Өдөр өнжүүлэхтэй сургуулиуд ¹

Бүх бага, дунд сургуулийн 40 хувь нь өдөр өнжүүлэхтэй ажилладаг.

Бага ангийн хүүхдүүдийн 25 хувь нь (6-11 настай) сургуулийнхаа эсхүл сургуулиасаа гадуур өдөр өнжүүлэхтэй сургуульд ангид явдаг. Зүүн Германд сургуулиудыг өдөр өнжүүлэхтэй болгох бодлогыг амжилттай хэрэгжүүлснээр нийт хүүхдүүдийн 73 хувь өдөр өнжүүлэхтэй сургуульд суралцдаг байхад холбооны хуучин улсуудад хүүхдүүдийн дөнгөж 19 хувь хамрагдаж байгаа нь асар том ялгаа байгааг харуулж байна.

(Эх сурвалж: Гэр бүл, хөдөлмөр эрхлэлтийг сургуулийн хүүхдүүтэйгээ хослуулах боломжийн талаар хийсэн судалгаа, Холбооны гэр бүл, ахмадууд, эмэгтэйчүүд, залуучуудын яам, 2011 оны 5 сар)

Германы ард түмний боловсролын түвшин

Ард түмний сургуулийн боловсрол:

Одоо дунд сургуульд суралцаж буй :	3,7 %
Бүрэн бус дунд сургууль төгссөн:	38,4 %
Бүрэн дунд буюу түүнтэй адилтгах сургууль төгссөн	27,9 %
Мэргэжлийн дээд/дээд сургууль төгссөн	25,3 %
Сургууль төгсөөгүй	3,9 %

Ард түмний боловсролын системээс гарахдаа мэргэжил эзэмшсэн байдал:

Хосолсон системтэй мэргэжил заах/олгох сургалт /МЭСҮТ/:	50,4 %
Мэргэжлийн сургууль төгссөн	7,4 %
Мэргэжлийн дээд сургууль төгссөн	5,1 %
Дээд сургууль төгссөн	7,4 %
Доктор хамгаалсан	1,1 %
Мэргэжил эзэмшээгүй	27,8 %

(Эх сурвалж: Холбооны статистикийн алба 2010 он, 2009 оны тоо баримт)

¹ Өдөр өнжүүлэхтэй сургууль: „долоо хоногт гурваас доошгүй өдөр, өдөр бүр долоо буюу түүнээс дээш цагийн хичээл заадаг, өдөрт нэг удаа хоол өгдөг, өдөрт нэг удаа хичээлээс гадуур, гэхдээ хичээлийн сэдэвтэй холбоотой, арга хэмжээ явуулдаг сургуулийг өдөр өнжүүлэхтэй сургууль гэнэ.” гэж Соёлын сайд нарын дунд сургуулийн тухай бага хурлаас тодохойлжээ.

Германы сурагчдын тоо, ерөнхий боловсролын сургуулиуд

Цэцэрлэг, сургуулийн бэлтгэл анги	0,3%
Бага сургууль	32,1%
Ерөнхий сургууль (Hauptschule)	8,0%
Ахлах сургууль (Realschule)	13,3%
Гимнази	28,1%
Хэд хэдэн боловсролын шаттай сургуулиуд, Нийт сургууль (Gesamtschule), мэргэжлийн баримжаа олгох сургалт	12,3%
Гүнзгийрүүлсэн сургалттай сургуулиуд	4,3%
Бусад (Чөлөөт Вальдорфын сургууль, оройн сургууль, коллеж)	1,6%

(Эх сурвалж : Холбооны статистикийн алба, 2010/2011 оны хичээлийн жил)

Сургууль завсардагчдын нийт сурагчдын дунд эзлэх хувь 2003 онд 8,9% байсан бол түүнээс хойш тогтмол буурсаар 2009 оны байдлаар 6,5% болжээ.

(Эх сурвалж: Холбооны статистикийн алба)

Сургууль дэвшилт

- Илүү гүнзгийрүүлсэн сургалттай сургуульд дэвшин суралцагсдын тоо нэмэгдэж байна: ерөнхий сургуульд суралцагчид цөөрч, гимназид суралцагсдын тоо нэмэгдэх хандлагатай байна.
- 2009 онд их дээд сургуульд эхлэн суралцагчдын тоо нэмэгдэж, суралцах эрх авагсдын ойролцоогоор 75 хувь нь их дээд сургуульд элсэн суралцаж байна.
- Хэрэв эцэг эхийн аль нэг нь дээд сургууль төгссөн бол хүүхэд нь дээд сургуульд сурах магадлал илэрхий өндөр байдаг.

(Эх сурвалж: Германы боловсрол 2010 онд, ССК, ХБСШЯ)

Герман оюутнуудын мэргэжил сонголт (2009/2010 оны сүүлийн хагас жил)

Хэлний болон соёлын шинжлэх ухаан	19,4%
Биеийн тамир	1,3%
Эрх зүй, эдийн засаг, нийгмийн шинжлэх ухаан	31,5%
Математик, байгалийн шинжлэх ухаан	17,7%
Ангаах/эрүүл мэндийн шинжлэх ухаан	5,6%
Мал эмнэлэг	0,4%
Хөдөө аж ахуй, ой ба хүнс судлал	2,0%
Техникийн шинжлэх ухаан	18,1%
Урлаг, урлаг судлал	3,8%
Бусад	0,1%

(Эх сурвалж: Холбооны статистикийн алба)

Цагаач иргэд боловсролын системд

Бусад адил түвшинтэй орнуудтай харьцуулахад германд иргэдийн сурч боловсрох боломж иргэдийн үндэс угсаа, нийгмийн гаралаас илүү ихээр хамаарч байна. Цагаач гаралтай залуус харьцангуй доогуур түвшний сургуульд илүү олноороо суралцдаг ажээ. Хэдийгээр нийгэм, эдийн засгийн байдлын хувьд герман иргэдтэй ижил түвшинд амьдардаг ч гэсэн герман хүүхдүүдтэй харьцуулахад хоёр дахин илүү тоотойгоор ерөнхий сургуулиудад суралцаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн системд цагаач гаралтай залуу хөвгүүд хамгийн муу сурлагатай байдаг. Сургуулиа дүүргэж чадахгүй орхиж буй цагаач хүүхэд залуусын тоо герман хүүхэд, залуучуудынхаас даруй хоёр дахин их байна.

(Эх сурвалж: Германы боловсрол 2010 онд, ССК, ХБСШЯ ба: Бэрхшээлтэй шилжилтээс зайлхийх – Нөөц хүчийг ашиглах, Фридрих-Эбертийн сан, 2011 оны 7 сар)

III. Хөдөлмөрийн зах зээл

Германы ажилгүйдлийн квот, 2011 оны 7 сарын байдлаар

Германы ажилгүйдлийн квот	6,9
эрэгтэйчүүд	6,8
эмэгтэйчүүд	6,9
15-аас 25 настай	5,4
15-аас 20 насныхан	3,1
20-оос 25 насныхан	6,4
50-аас 65 насныхан	7,8
55-аас 65 насныхан	8,4
Гадаадын иргэд	14,3
Германы иргэд	6,2

20-оос 25 насны залуучуудын дунд ажилгүйдэл харьцангуй өндөр байгаа нь мэргэжлийн сургуулиа төгсөөд ажлын гараагаа эхлэх үед олон бэрхшээлтэй тулгардагтай холбоотой. 20-оос 25 насныхны дунд ажилгүйдэл өндөр байгаа боловч тэдний ажилгүй байх хугацаа нь тэднээс дээш насныхантай харьцуулбал илүү богинохон байдаг. 20-иос доош насныхны дунд ажилгүйдлийн тоо бага байдаг нь энэ насныхны дийлэнх нь мэргэжлийн сургалтанд хамрагдагсад байдагтай холбоотой.

Германы мэргэжлийн сургалтын зах зээлийн өнөөгийн байдал

	2010/2011	Өмнөх оны тухайн сартай харьцуулахад абсолют тоогоор хувиар	
Герман улс			
Бүртгэлтэй мэргэжлийн сургуулиуд	444.000	+ 40.000	9,9
түүнээс үйлдвэрлэл дээрх	431.000	+42.000	10,8

сул орон тоо	169.000	+24.000	16,6
суралцах хүсэлтээ илэрхийлсэн	473.000	-9.000	-1,8
суралцах газраа олоогүй	183.000	-12.000	-6

Б ГСДН-ын гэр бүл, боловсролын бодлого

I. Манай намын засгийн эрхийг барьж байх хугацаандаа хэрэгжүүлсэн бодлого

1998-аас 2009 он хүртэл ГСДН нь засгийн эрхийг барьж, 1998-аас 2009 он хүртэл ГСДН Холбооны канцлерыг өөрийн эгнээнээс сонгон ажиллуулж байлаа. Энэ хугацаанд бид гэр бүлийн бодлогын ерөнхий нөхцлүүдийг шинэчлэн сайжруулсан. Жишээлбэл: бид эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн хүйсийн тэгш байдал, ажил мэргэжлээ гэр бүлтэйгээ хослуулах боломжийг сайжруулах чиглэлээр олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Бусад тодорхой жишээнүүдийг дурьдвал:

Орон даяар хүүхэд асрах, саатуулах газруудыг байгуулах

Хууль эрх зүйн үндэс нь:

- **Хүүхдийг дэмжих хууль**
Хүүхдийг дэмжих хуулийн (ХүДэХу, 2009 оноос хүчин төгөлдөр болсон.) дагуу хүүхэд асрах саатуулах газруудыг байгуулах ажлыг эрчимжүүлсэн.
- **2013 оноос нэгээс гурван настай хүүхдийн яслид хамрагдах эрхийг хуульчилсан.**
2013 оноос Холбооны улс даяар гурваас доош насны бүх хүүхдийн 35 орчим хувийг яслийн орон тоогоор хангах зорилтыг дэвшүүлсэн. Мөн нэгээс гурван настай хүүхэд бүрийг яслид хамрагдах эрхийг хуулиар баталгаажуулсан.

Хөрөнгийн эх үүсвэр:

- **Нэгээс гурван насны хүүхдийн яслийн орон тоог** баталгаажуулахын тулд холбооноос 2013 он хүртэл 4 сая еврогийн хөрөнгө оруулалтыг хийнэ. /үйл ажиллагаа, ажиллах хүчний зардалд/
- 2011 – 2014 онд 400 сая еврогийн нэмэлт санхүүжилт хийхээр төлөвлөсөн. Энэ хөрөнгөөр „Хэл ба интеграц“ буюу хэлний сургалттай 4.000 яслийн орон тоог нэмэх болно.
- 2014 оноос жил бүр 770 сая евро зарцуулна.

ГСДН нь 15 ба 16-р сонгуулийн хугацаанд гэр бүлийн бодлогын шинэчлэлийг эхлүүлсэн:

- 2007 онд эцэг эхийн мөнгийг бий болгосон. Эцэг эхийн аль нэг нь хүүхдээ асрах чөлөө авч эцэг эхийн мөнгийг (цэвэр цалингийн 67 хувь) нэг жилийн туршид авах эрхтэй. Мөн аавуудыг хүүхдээ асрах чөлөө авахад урамшуулах зорилгоор хоёр сарын хосын чөлөө нэмж авах боломжийг нэвтрүүлсэн.

- Гурав хүртэлх насны хүүхдийн яслийн орон тоог цаашид нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлсэн.
- „2020 он хүүхдийг өдөр өнжүүлэхтэй сургуульд сургах мастер төлөвлөгөөг“ баталсан: Уг төлөвлөгөөний дагуу 2015 он хүртэл өдөр өнжүүлэхтэй сургуулиудын орон тоог 19.000 хүртэл нэмэгдүүлж 2020 он хүртэл холбооны улсуудтай хамтран хэрэгцээний хэрээр орон даяар өдөр өнжүүлэхтэй сургуулиудыг байгуулна.

II. Бундестаг дахь ГСДН-ны бүлгийн 2011-2013 оны боловсролын салбарт хэрэгжүүлэх хөтөлбөр

1. Бүх нийтийг боловсролтой болгох –эхнээс нь эхлэн
 - Хувь хүний авьяас чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн өдөр өнжүүлэхтэй сургуулийн орон тоог нэмэгдүүлэх
 - Яслийн чанарыг сайжруулах, хэлний сургалттай яслийг байгуулах
 - Хүүхдийн ясли, цэцэрлэгийг төлбөрөөс бүрэн чөлөөлөх
 - Сургууль төгсөлтийг дэмжих, хүссэн үедээ сургуулиа төгсөх боломж олгох
2. Боловсролын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
 - Өндөр орлоготой иргэдэд сургалтын төлбөр ногдуулах
3. Холбооны сургалтыг дэмжих хууль (ХоСуДэХ / ВAföG)²
 - ХоСуДэХ нь боловсролын салбарт тэгш байдлыг хангах улс төрийн гол зэвсэг бөгөөд цаашид ч хэвээр байх болно.
 - 11-р ангиас эхлэх сурагчдад ХоСуДэХ-ийн дагуу мөнгө олгох
 - Хагас өдрөөр ажиллах нөхцөл болон мэргэжил дээшлүүлэх сургалтыг дэмжих
 - ХоСуДэХ мөнгийг амьжиргааны зардалд тохируулан байнга өөрчлөх
 - Дунд мэргэжилтэй хүмүүст мэргэжлээ дээшлүүлж дээд сургуульд суралцах боломж олгохын тулд ХоСуДэХ мөнгийг 30-аас дээш насныханд олгох
4. Германд суралцахад
 - Сургалт үнэ төлбөргүй
 - Их, дээд сургуульд элсэн суралцагсдын тоо болон суралцах орон тоог нэмэгдүүлэх
 - Холбооны улс даяар их дээд сургуульд элсэн суралцах нэгдсэн шалгууруудыг нэвтрүүлэх
 - Их дээд сургуулиудыг илүү нээлттэй болгох: Мэргэжилтэй ажиллах хүчнийг их дээд сургуульд суралцах элсэлтийн шалгалтгүйгээр их, дээд сургуульд элсэн суралцах боломж олгох
5. Мэргэжил олгох сургалт /МЭСҮТ/
 - 20-иос дээш насны бүх хүмүүсийн бүрэн дунд боловсролтой эсэх, мэргэжил эзэмшсэн эсэхээс үл хамааран мэргэжил олгох сургалтанд хамрагдах баталгааг хангах
 - Мэргэжил олгох хосолмол системийг бэхжүүлэх, сурах мэргэжлүүдийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх
 - Үйлдвэрлэл дээр сурах боломжийг дээд сургуультай хослуулах

² Суралцахыг хүссэн иргэнд сурахад нь шаардлагатай мөнгө байхгүй бол өөрийн хүсэл, сонирхолдоо нийцсэн, чадах хэмжээний мэргэжлээрээ суралцахад нь дэмжлэг болгон улсаас мөнгө олгох арга хэмжээ. (Брокхауз)

- Үйлдвэрлэл дээрх сургалтын орон тоог нэмэгдүүлэхийн тулд үйлдвэрийн ажилчдын зөвлөлд ажилчдын шийдвэр гаргалтанд оролцох эрхийг илүү баталгаажуулах
6. Мэргэжил дээшлүүлэх
- Мэргэжил дээшлүүлэх боломжийг нэмэгдүүлэх, мэргэжил дээшлүүлэх эрхийг хуулиар баталгаажуулах
 - Цагаач иргэдийн мэргэжлийг дээшлүүлэх, хэлээ сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх
 - Мэргэжил олгох сургалт төгсөгчдөд мэргэжлийн дээд сургуулийн болзлыг хангах түвшний мэдлэг олгох, их сургуулиудыг илүү нээлттэй болгох

С Германы Бундестаг болон Германы Бундестаг дахь намын бүлгүүд залуучуудыг улс төрд татахын тулд юу хийдэг вэ?

Германы Бундестагийн хөтөлбөрүүд

- **Гишүүдийн урилгаар Германы Бундестагтай танилцах**

Бундестагийн 621 гишүүн тус бүр жилд 230 хүн, сургуулийн анги, бусад бүлгүүдийг Берлин хотноо урих эрхтэй. Тэдэнд унааны зардлын хөнгөлөлт үзүүлж хуралдааны ажиллагаанд ажиглагчаар оролцох эсхүл райхстагтай танилцах, урьсан гишүүнтэй уулзаж ярилцах боломжийг олгодог.

Түүнээс гадна гишүүд жил бүр Холбооны хэвлэлийн албатай танилцах (ХХА-ын аялалууд), тус бүр 50 хүнээс бүрдсэн 3 бүлгийн аялалыг зохион байгуулдаг. Уг хөтөлбөрийн хүрээнд яамд, түүх дурсгалын газруудтай танилцах, хот үзэх болон чуулганы хуралдааны ажиллагаатай танилцах, гишүүдтэй уулзаж ярилцах зэрэг арга хэмжээнүүд явагддаг.

- **Залуучууд ба парламент**

Холбооны улсын хэмжээгээр 312 хүүхэд залуучууд өөрийн тойргийн гишүүний урилгаар энэ арга хэмжээнд оролцдог. Залуучууд ба парламент нь „Тоглоомын хэлбэрээр парламентын ардчилалтай танилцах“ сэдэвт төлөвлөгөөт тоглоомын өргөтгөсөн хэлбэр юм.

- **Гишүүдийн ажлын албанд дадлага хийх**

Сургуулийн сурагчид, оюутнууд гишүүдийн ажлын албанд дадлага хийдэг. Энэ дадлагыг Берлинд эсхүл аль нэг гишүүний сонгуулийн тойрогт хийж болно. "Гимназид мэргэжлийн чиг баримжаа олгох нь " (BOGI) сэдэвт хөтөлбөрийн хүрээнд сурагчид, дадлагажигчид нэгээс гурван долоо хоног дадлага хийх боломжтой.

- **Олон улсын парламентын тэтгэлэг (IPS)**

Олон улсын парламентын тэтгэлэгийг дундад, өмнөд, зүүн өмнөд европ, Израиль, Франц болон АНУ-ын оюутан залуучуудад олгодог, Берлиний гурван их сургуультай хамтран хэрэгжүүлдэг хөтөлбөр юм. Сургалтын тэтгэлэгээр суралцагсад нь Бундестагийн гишүүдийн ажлын албанд зургаан сарын дадлага

хийж, байнгын хорооны болон ажлын хэсгийн хуралд сууж гишүүдийн уулзалтанд оролцон гишүүдийн ажилд тусалдаг. 2011 оны байдлаар 27 орны 115 хүн энд оролцож байна.

- **Охидын өдөр**

Бундестагийн гишүүд Холбооны бүх улсуудаас охидыг Берлин хотноо урьж нэг өдрийн турш улс төрийн болон гишүүдийн ажилтай танилцуулдаг. Үүний цаад шалтгаан нь: Олон охид, залуу бүсгүйчүүд зөвхөн "эмэгтэйчүүдийн мэргэжил" гэж нэрлэгддэг, конторын ажилтан, асаргаа, сувилгаа, үсчин болон хүмүүнлэгийн шинжлэх ухааныг л сонирхдог ба МИБТ-ажил гэгдэх: математик, информатик, байгалийн шинжлэх ухаан болон техникийн мэргэжлүүдийг сонирхдоггүй.

- **Хүүхдийн өдрүүд**

Жилд дөрвөн удаа тохиодог хүүхдийн өдрүүдээр таваас 14 хүртэлх насны сургуулийн хүүхдүүд, бүлгүүд Райхстагийг хүүхдэд зориулсан тусгай тайлбартайгаар үздэг.

- **„Бөмбөлгийг харагч“ нэртэй хүүхдэд зориулсан Бундестагийн вэб сайт**

Энэхүү онлайн порталаар парламентын ажиллагааг хүүхдүүдэд ойлгомжтой тайлбарладаг. Мэйлээр парламентын төлөөлөгчид, хүүхдийн комисстой харилцаж болно.

Германы Бундестаг дахь намын бүлгүүдийн улс төрийн үйл ажиллагаа

- **Залуучуудын хэвлэл мэдээллийн өдрүүд**

2001 оноос хойш Бундестаг дахь ГСДН-ын бүлэг сургуулийн сонины 16-25 насны залуу редакторуудтай хамтран залуучуудын хэвлэл мэдээллийн өдрийг зохион байгуулдаг. Хөтөлбөрийн хүрээнд Бундестагийн гишүүд, ГСДН-ын хэвлэл мэдээллийн ажилтнууд болон нийслэлийн хэвлэл мэдээллийн төлөөлөгчидтэй уулзалт хийдэг.

- **Үйлдвэрчний эвлэлийн залуу үе**

Бундестаг дахь ГСДН-ын бүлэг 2006 оноос эхлэн Үйлдвэрчний эвлэлийн залуу үед зориулсан арга хэмжээг зохион байгуулж байна. 2011 онд “Зүүний нам” анх удаагаа хамтран зохион байгуулж байна. 18-аас 35-насныхан энэ арга хэмжээнд оролцдог. Оролцогчид нь: орон тооны болон сайн дурын үйлдвэрчний эвлэлийн ажилтнууд юм. Оролцогчид гишүүдийн ажлын алба болон ГСДН-ын бүлгийн улс төрийн ажил болон гишүүдийн ажил байдалтай танилцдаг.

Нэмэлт тайлбар: Холбооны улсууд дахь залуучуудын оролцоо

Баден Вюрттембергийн эвслийн гэрээ:

ГСДН ба Ногооны намын эвслийн гэрээнд „Залуучуудын оролцооны тухай“ тусгай бүлэг оруулан хүүхэд залуучуудын оролцох эрхийг хангахын чухлыг онцлон дурдаад: Хүүхэд залуучуудын бодлогыг залуучуудтай хамтран хэрэгжүүлэх ёстой гэж тосгоны

журамд хуульчлан заажээ. Тосгоны залуучуудын төлөөлөгчидийн тосгоны зөвлөлд /тосгоны иргэдийн хуралд/ үг хэлэх, хүсэлт өргөдөл гаргах эрхийг хуульчлан баталгаажуулсан. Сонгууль өгөх насыг 16 болгож бууруулав.

Бремений эвслийн гэрээ:

Улс төрийг залуучуудад нээлттэй, ил тод болгож, залуучуудад хандан тэдний хаа байгаа газар нь очиж улс төрийн үйл ажиллагааг явуулах ёстой гэж Бремений ГСДН ба Ногооны намын эвслийн гэрээнд заажээ. Хүүхэд залуучуудын оролцоог ялангуяа орон нутгийн түвшинд дээшлүүлж тэдний хүсэл, санаа бодолд илүү хүндэтгэлтэй хандаж хүлээн зөвшөөрөх нь чухал. Оролцоо нь Бременд байгуулагдсан залуучуудын зөвлөлүүд, нээлттэй хуралдааны талбар, эсвэл төсөлд чиглэсэн санал зэрэг тодорхой арга хэмжээнүүдэд биеллээ олж байна. Сонгуульд оролцож саналаа өгөх насыг Бременд ГСДН ба Ногооны намынхан 16 болгож бууруулсан.

Д „Залуучууд 2010 онд“ сэдэвт Шеллийн судалгаа

Залуучуудын талаархи Шеллийн 16 дахь судалгаа: Залуучуудын санхүү, эдийн засгийн хямралд хандаж буй хандлага

Германы өнөөгийн залуу үе ирээдүйдээ итгэл төгс байна: Тэдний итгэл төгс байдалд эдийн засгийн хямрал ч, найдвар муутай ажлын байр ч, тодорхойгүй ирээдүй ч саад болж чадахгүй байна. Өөдрөг үзэлтнүүдийн эгнээ тэр ч байтугай өссөн байна. Үүний зэрэгцээгээр нийгмийн байдал сул дорой гэр бүлийн хүүхэд залуусын итгэл найдвар улам буурсан. Чинээлэг, ядуу бүлгүүдийн хоорондох ялгаа улам нэмэгдэж байна.

Залуучуудын талаархи Шеллийн 16 дахь судалгаа ийм дүнтэй гарчээ. Уг судалгааг Бийлефелдийн нийгэм судлаачид профессор Др. Маттиас Альберт, профессор Др. Клаус Хуррелман, Др. Гудрун Күенцел нар болон Ульрих Шнееклотын удирдлага дор Мюнхений Судалгааны институтийн ТНС Инфратест нийгэм судлалын мэргэжилтний баг хамтран Германы Шелл судалгааны төвийн даалгавраар хийжээ. Үүнээс гадна энэ жилийн эхээр 12-оос 15 настай 2.500 гаруй хүүхэд залуусыг аж байдал, шашин шүтлэг, үнэт зүйлсийн тухай ойлголт болон улс төрд хандах хандлагынх нь талаар асуулга явуулсан.

Өөдрөг үзэлтний эгнээ нэмэгдсэн авч нийгмийн ялгаа улам хүчтэй болсоор

Сүүлийн хоёр удаагийн Шеллийн залуучуудын судалгааг хооронд нь харьцуулж үзэхэд өөдрөг үзэлт залуучуудын эзлэх хувь мэдэгдэхүйц нэмэгдсэн байна. Хүүхэд залуучуудын 59 хувь нь (2006: 50 хувь) ирээдүйгээ сайн сайхнаар төссөлж байхад, 35 хувь нь эргэлзсэн, 6 хувь нь итгэлгүй, гутранги үзлээр ирээдүйгээ угтаж байна. Нөгөө талаар нийгмийн байдлын хувьд сул дорой гэр бүлийн хүүхэд залуучуудын өөдрөг үзэл буурсан байна. Нийгмийн байдлын хувьд сул дорой гэр бүлээс гаралтай залуусын дөнгөж 33 хувь нь ирээдүйдээ итгэлтэй байна. Нийгмийн энэхүү ялгаа нь амьдралдаа хир зэрэг сэтгэл дүүрэн байдаг бэ? гэсэн асуултын хариултаар илэрч байна: Нийт залуусын бараг дөрөвний гурван хувь нь ерөнхийдөө амьдралдаа сэтгэл хангалуун байхад ядуулаг гэр бүлээс гаралтай хүүхэд залуучуудын дөнгөж 40 хувь нь эерэг хариу өгчээ.

Боловсрол хувь хүний намтрыг тодорхойлогч гол түлхүүр болсон хэвээр байна.

Цаашид ч ямар сургууль төгссөн, ямар мэргэжил эзэмшсэн бэ? гэдгээс тухайн хүний амжилт шалтгаалдаг, боловсрол амжилтанд хүрэх түлхүүр хэвээрээ байна. Германд бусад бүх орнуудаас илүүтэйгээр хүүхэд, залуучуудын боловсролын түвшинд нийгмийн байдал нь хүчтэй нөлөөлж байна. Дунд боловсролын үнэмлэхгүй залуус мэргэжлийн ажил, мэргэжлийн сургуульд элсэн орох нь ховор. Тийм ч учраас сургуулиа төгсөж чадна гэдэгтээ итгэлгүй залуус ирээдүйгээ ч итгэлгүй угтаж байна. Мэргэжил олгох сургалт, ажил хөдөлмөрийн гараагаа эхлэх талаар хүүхэд залуучуудын бодол илэрхий сайжирчээ. Мэргэжлийн сургалтанд хамрагдагсдын 76 хувь нь төгссөнийхөө дараа ажил олно гэдэгтээ итгэлтэй байна. Хүүхэд залуучуудын 71 хувь нь мэргэжлийн талаархи хүсэл мөрөөдөл нь биелэгдэнэ гэдэгт итгэлтэй байна. Нийгмийн байдлын хувьд тааруу хүүхэд залуучуудын дөнгөж 41 хувь нь ажил олно гэдэгтээ итгэлтэй байна.

Боловсролын салбарт хүйсний онцлогтой өөрчлөлт байнга явагдаж: Ойролцоогоор арван жилийн өмнөөс залуу эмэгтэйчүүд сургууль төгсөлтийн тоогоороо үе тэнгийнхээ залуучуудыг гүйцэн түрүүлж, улмаар сайн дүнтэйгээр төгсөхийг эрмэлзэх болов.

Залуучуудын дунд гэр бүлтэй болох эрмэлзэл өндөр хэвээр байна.

Залуучуудын дунд гэр бүл зохиох хандлага өссөн. Хүүхэд залуучуудын дөрөвний гурваас илүү хувь нь (76 хувь) аз жаргалтай амьдрахад гэр бүл хэрэгтэй гэдэгт бат итгэлтэй байна. Сургууль, мэргэжлийн сургалтын эхний жилүүдэд тавигдах шаардлага өндөрсөж буй өнөө үед хүүхэд, залуучууд эцэг эхийн зүгээс тавих анхаарал, сэтгэлийн дэмжлэгээр эдгээр бэрхшээлийг давдаг. Хүүхэд залуучуудын 90 гаруй хувь нь эцэг эхтэйгээ сайн харилцаатай байдаг. Тэдний ихэнх нь эцэг эхийнхээ хүмүүжлийн арга барилыг хүлээн зөвшөөрдөг байна. Бүх хүүхэд залуучуудын дөрөвний гурав орчим хувь нь хүүхдүүдээ эцэг эхийнхээ өөрсдийг нь хүмүүжүүлсэн арга барилаар хүмүүжүүлэх бодолтой ажээ. Бүх хүүхэд залуучуудын дөрөвний гурав орчим хувь нь өртөг багатай бөгөөд ая тохьтой учир эцэг эхтэйгээ хамт амьдарч байна.

Хүүхэдтэй болох хүсэлтэй залуучуудын тоо нэмэгдэж байна. Хүүхэд залуучуудын 69 хувь нь хүүхэдтэй болохыг хүсэж байна. Залуу эмэгтэйчүүдийн (73 хувь) хүүхэдтэй болох хүсэл залуу эрчүүдээс (65 хувь) илүү байна.

Залуучууд интернетэд

Хүүхэд залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх байдал нь нийгмийн гарлаас хамаарч өөр өөр байна. Хөрөнгө чинээтэй айлын хүүхдүүд ном унших, бүтээлч сэтгэлгээ шаардсан ажил хийх, олон талт нийгмийн харьцаагаа хөгжүүлэхэд чөлөөт цагаа зарцуулдаг бол нийгмийн байдал тааруу гэр бүлээс гаралтай хүүхдүүд ихэнх цагаа компютерийн өмнө эсхүл зурагт үзэж өнгөрүүлдэг. Харин нийтлэг нэг зүйл байгаа нь: Бараг бүх хүүхэд залуучууд (96 хувь) интернетэд холбогдох боломжтой. Үүгээр зөвхөн интернет хэрэглэгчдийн тоо өссөн биш, харин хэрэглэдэг цаг нь ч өссөн. Хүүхэд залуучууд долоо хоногт дунджаар 13 цаг интернет ашиглаж байна.

Интернетийг ашиглаж байгаа хэлбэр нийгмийн ялгааг бас дахин – ялангуяа эрэгтэй хэрэглэгчдийн хувьд харуулж байна. Нэн ялангуяа нийгмийн байдлын хувьд сул дорой гэр бүлээс гаралтай залуу хөвгүүд /интернетийн холбоотой хүүхэд залуучуудын 24 хувь/ интернетэд ихэнх цагаа компютерийн тоглоомоор тоглож өнгөрүүлдэг. „Тоон

сүлжээний холбоог ашиглагчид“ (25 хувь) – ихэвчлэн залуу охидууд нийгмийн сүлжээгээ бэхжүүлэхэд (Фэйсбүүк/Facebook, ШтудиФауЦ/StudiVZ) ашигладаг. „Интернетийг хэрэглээ хэлбэрээр ашиглагчдын“-ийн хувьд (17 хувь) – насаар арай ахмад залуу эмэгтэйчүүд – интернетийг зөвхөн хэрэгцээгээ хангах зорилгоор ашигладаг: Тэд мэдээлэл авах, E-мэйл бичих, авах, гэртээ сууж байгаад юм худалдаж авах зэрэгт интернетийг ашигладаг ажээ. „Олон талт хэрэглэгчид“ (34 хувь) – дээд давхаргын насаар арай ахиу залуу эрэгтэйчүүд – интернетийг бүх хэлбэрээр нь бүхэл боломжийг нь дайчлан ашигладаг. Залуучуудын Шеллийн судалгаа интернетийн хэрэглээний талаар 2002 оноос хойш тасралтгүй судалгаа явуулж байна.

Улс төрийг сонирхох сонирхол бага зэрэг нэмэгдэж байна.

Хэдийгээр хүүхэд, залуучуудын улс төрийг сонирхох сонирхол 1970-аад ба 1980-аад онуудын түвшингээс илэрхий доогуур байгаа хэвээр боловч улс төр сонирхогчдын тоо дахин бага зэрэг өссөн. Дунд ба дээд давхаргынхан болон хүүхэд залуучууд энэ өсөлтийг бүрдүүлж байна. 12-оос 14 настай хүүхдүүдийн улс төрийг сонирхол сүүлийн найман жилийн дотор бараг хоёр дахин өсөж 21 хувь болсон ба 15-аас 17 настай залуу хөвгүүдийнх 20 хувь байснаа 33 хувь болж өссөн.

Хүүхэд залуучуудын ихэнх нь улс төрийн зүүн ба дундаж хандлагатай байна. Нийгмийн байгууллагуудад итгэх итгэлд мөн бага зэрэг өөрчлөлт орсон: Цагдаа, шүүх, Холбооны арми болон хүний эрх, байгаль орчныг хамгаалах бүлгүүдэд үзүүлэх итгэл өндөр, харин засгийн газар, сүм, компаниудад итгэх итгэл сул байна. Сүүлийн эдийн засгийн хямралын дараагаар хүүхэд залуучууд эдийн засаг, санхүүд итгэл суларсан байна. Нэн ялангуяа банкуудад итгэх итгэл хамгийн ихээр буурсан байна.

Хэдийгээр улс төр болон намуудын нэр хүнд муу, итгэл алдарсан байдал их байгаа боловч хүүхэд залуучууд улс төрийн идэвх бага зэрэг сэргэж буй байдал ажиглагдаж байна. Нэн ялангуяа уг асуудал тухайн хувь хүнд чухал бол идэвхтэй оролцдог. Өөрт нь хэрэгтэй бол залуучуудын 77 хувь нь гарын үсэг зурах ажиллагаанд оролцоход бэлэн гэжээ. Мөн залуучуудын 44 хувь нь жагсаалд оролцоход бэлэн гэжээ. Охид хөвгүүдээс улс төрийн идэвх сайтай нь харагдлаа.

Нийгмийн идэвх санаачилгаа дээшлүүлж , настангуудыг илүү ойлгох шаардлагатай байна.

Өнгөрсөн жилүүдтэй харьцуулахад илүү олон хүүхэд залуучууд нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог болсон байна: Тэдний 39 хувь нийгмийн болон олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна. Энд ч мөн нийгмийн ялгаа харагддаг. Нийгмийн идэвх, оролцоо мөн боловсрол, нийгмийн давхаргаас хамааралтай. Залуучууд боловсрол өндөртэй, нийгмийн байдал сайтай байх тусмаа өдөр тутам сайн үйлсийн төлөөх үйл ажиллагаанд оролцдог.

Германы бүхэлдээ насжиж буй нийгэм хүүхэд залуучуудыг асуудал хэмээн үздэг хэвээр байна. Хүн амын талаас илүү хувь нь ахмад үе болон залуу үеийн хоорондох харьцааг зөрчилтэй гэж үздэг. Гэсэн хэдий ч ахмад настанд хүндэтгэлтэй хандаж тэдний амьдралын хэвшилийг ойлгодог залуучуудын тоо нэмэгдсээр байна. Энэ хандлага ахмад ба залуу үеийн хоорондох нийгмийн баялаг, хангалуун чинээлэг амьдралын хувиарлалтын тухай ойлголтонд тусгалаа олж байна. Залуучуудын 47 хувь нь нийгмийн баялгийн хувиарлалт шударга байна гэж үздэг. Залуучуудын зөвхөн 25 хувь нь настайчууд шаардлагаа бууруулах хэрэгтэй, хэт их зүйлийг шаардаж байна гэж үздэг.

Залуучуудын дийлэнх нь даяарчлалыг эерэгээр үнэлдэг.

Хүүхэд залуучуудын 84 хувь нь даяаршлыг юуны өмнө бүх дэлхийгээр аялах, суралцах, ажиллах эрх чөлөө гэж үздэг. Нөгөө талаар дэлхий дахиныг хэрсэн сүлжээ бий болсноор эдийн засгийн хангалуун байдлыг нэмэгдүүлнэ гэж үзэх хандлага нэмэгдэж байна. Даяаршилд хандах дээрх хандлага эдийн засаг, санхүүгийн хямралын өмнө 2006 онд зөвхөн 37 хувь байсан бол 2010 онд 53 хувь болон өсчээ. Үүний зэрэгцээ даяаршлыг байгаль орчны сүйтгэлтэй холбож үзэх нь элбэг байдаг. Ерөнхийдөө даяаршилд хандах гурван өөр хэв шинжийг тогтоож болно: Даяаршлыг дэмжигч, даяаршлыг эсэргүүцэгч болон даяаршлыг шинжээчид. Даяаршлыг дэмжигчид нь нэн түрүүнд эдийн засгийн хангалуун байдал, энх тайван, ардчиллыг гүнзгийрүүлэх боломж гэж үзэж байна. Даяаршлыг эсэргүүцэгчдэд бол зөвхөн их хэмжээний байгаль орчны сүйтгэл, ажилгүйдэл, ядуурал ба хөгжлийн буурай дорой байдал л харагдаж байна. Даяаршилд шүүмжлэлтэй, ялгавартай ханддаг шинжээчид хөгжиж буй даяаршлын сайн ба муу талыг дэнслэн цэгнэж байна.

Цаг уурын өөрчлөлт дэлхий нийтийн асуудал болжээ.

Өнөө үед хүүхэд залуучуудын сэтгэлийг хамгийн ихээр зовоож байгаа асуудал бол цаг уурын өөрчлөлт юм. 76 хувь нь цаг уурын өөрчлөлтийг том, тэр ч байтугай маш том асуудал гэж үзэж байна. Гурван залуус тутмын хоёр нь цаг уурын өөрчлөлт нь хүн төрөлхтний оршихуйд аюул учруулна хэмээн үзэж байна. Цаг уурын өөрчлөлтийг шүүмжлэгчид экологийн өөрчлөлтийн бурууг өндөр хөгжилтэй баян орнуудад тохдог. Цаг уурын өөрчлөлтөнд өөдрөгөөр хандагчид хэдийгээр цаг уурын өөрчлөлтөд шүүмжлэлтэй ханддаг ч олон нийт хэтэрхий эмзэг хандаж байна гэж үздэг. Хувь заяатайгаа эвлэрсэн ажиглагчдын бараг тал хувь нь цаг уурын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээ авахад хэтэрхий оройтсон гэж гэж үздэг.

Хүүхэд залуучуудын нэг хэсэг нь өөрийн байгаль орчинд хандах хандлагадаа дүгнэлт хийж, байгаль орчинд халгүй амьдралын хэв маягаар амьдрахыг эрхэмлэх болжээ. Юутай ч хоёр хүний нэг нь өдөр тутмын амьдралдаа эрчим хүчээ хэмнэж, 44 хувь нь аль болохоор машинаар явалгүй дугуй унаж 39 хувь нь бага зарцуулалттай жижиг оврын машин унах зэрэг арга хэмжээ авч байна. Үүнээс гадна цаг уурын байдалд онцгой шүүмжлэлтэй ханддаг залуус байгаль орчныг хамгаалах ажилд илүү идэвхтэй оролцож байна.

Залуучуудын дунд шашин шүтлэг төдийлөн чухал биш үүрэгтэй хэвээр байна.

Германы хүүхэд залуучуудын дунд шашин шүтлэг төдийлөн чухал бус рольтой хэвээр байна. Гэхдээ хоорондоо асар ялгаатай шашин шүтлэгийн гурван хэлбэр зэрэгцэн оршдог: Шинэ Холбооны улсуудын ихэнх залуучуудын хувьд шашин шүтлэг ач холбогдлоо гээсээр байхад, хуучин Холбооны улсуудад төдийлөн онцгой бус ч ач холбогдолтой хэвээр байна. Католик шашинтай хүүхэд залуучуудын дөнгөж 44 хувьд л бурхан чухал ажээ. Харин цагаач гаралтай хүүхэд залуучуудын хувьд байдал эсрэгээрээ: Тэд шашин шүтлэгтэй үнэнч ба сүүлийн арван жилд улам их ач холбогдолтой болсон байна.

Залуус прагматик хандлагатай байгаа нь өнөөгийн нөхцөлтэй төдийлөн авцалдахгүй байна.

Хүүхэд залуучуудын амьдралд хандах хандлага, үнэлэмж прагматик хэвээр байна: Ур чадвар, өндөр бүтээмж шаардсан өнөөгийн хэрэглэгч нийгэмд залуучуудын хувийн амжилт маш чухал. Ур чадвар, бүтээмж бүхний хэмжүүр биш: Хэдийгээр хүүхэд залуучуудын 60 хувь нь ажилсаг хичээнгүй байдлаараа дээгүүр үнэлэгдэх боловч амьдралын баяр баягалан байх ёстой гэж үздэг. Залуучуудын 57 хувь нь баяр баясгалангаар дүүрэн амьдрахыг хүсч байна. Өөдрөг үзэлтэй, өөрийн амьдралдаа сэтгэл дүүрэн залуучуудын хувьд зөвхөн өөрөө урагш ахих нь хангалттай бус, харин гэр бүл, найз нөхөд, таньдаг хүмүүсээс нь бүрдэх нийгмийн орчиндоо санаа тавьдаг. Нийгэмд болж буй үйл явдлуудыг сонирхдог.

Өнөөгийн залуус хүмүүс бүгдэд тэгш үйлчилдэг, бүгдээрээ дагаж мөрддөг нийгмийн ёс суртахууны хэм хэмжээг шаардаж байна. Нийтээрээ дагаж мөрддөг нийгмийн ёс суртахуунтай байх нь залууст өөрийнхөө өмнө хариуцлага хүлээх, бусдаас хараат бус амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд нь зайлшгүй шаардлагатай. Залуусын 70 хувь нь хөдөлмөрийн ертөнц, нийгэм дэх муу муухай зүйлсийн эсрэг тэмцэх ёстой гэж үзэж байна.

Судалгааны арга зүй, уламжлал

Шелл судалгааны институт нь 1953 оноос хойш хүүхэд залуучуудын хандлага, сэтгэл санааны байдал, хүлээлтийн талаархи судалгаануудыг тасралтгүй хийж байна. Шеллийн залуучуудын судалгаа өдгөө 16 дахь жилдээ нийтлэгдэн гарахдаа зөвхөн залуучуудын тухайн үеийн хандлагыг тодорхойлоод зогсохгүй нийгмийн бодлогын тодорхой санал дэвшүүлж, шаардлагатай сэдвүүдээр олон нийтийн хэлэлцүүлгэ хийх санааг өгдөг. Уг судалгаа нь олон жилийн туршид бий болсон мэдээллийн бааз дээр тулгуурлан нийгэм, улс төрийн үйл ажиллагаагаа тодорхойлох боломжийг шийдвэр гаргагчдад олгодог. Германы Шелл судалгааны төв энэхүү хүүхэд залуучуудын судалгааг тогтмол явуулснаараа залуучуудын өмнө нийгмийн хариуцлагыг хүлээх болсон байна.

(Германы Шелл Холдинг ХХК-ийн 2010 оны есөн сарын 14-ний хэвлэлийн мэдээлэл)

Е Хүүхэд залуучуудын идэвх санаачлага

І. Идэвх санаачлага гэж юу вэ?

Ардчилал нь зөвхөн нийт иргэдийнхээ ардчилсан идэвх санаачлага дээр тулгуурласан нөхцөлд амжилттай оршин тогтнож чаддаг. Ардчилсан нийгэмд хүн бүр өөрийн санааг нэмэрлэж, зөвхөн өөрийнхөө төлөө бус өрөөл бусдын өмнө хамтын хариуцлага хүлээж, хамтын шийдвэр гарган хувь нэмрээ оруулах ёстой.

Иргэний ардчилсан нийгэм нь бүх иргэдийнхээ улс төр, соёл, нийгэм, эдийн засгийн амьдралд оролцох оролцоог хангах ёстой гэдэг утгаараа нийгмийн нэгдлийг хангагч цөм нь байх ёстой. Иргэдийн идэвх санаачлага ба иргэдийн харилцан бие биенийхээ өмнө хариуцлага хүлээх байдал нь бат бэх нийгмийн гагнаас юм. Төр дангаараа дээрх үүргийг биелүүлэх гэвэл төрийн хүчин хүрэлцэхгүй.

Иргэдийн идэвх санаачлага олон талтай: Өөртөө туслах бүлгүүдийн үйл ажиллагаанд оролцох, улс төрийн оролцооноос эхлээд сонгодог хэлбэрийн сайн дурын алба, мөнгөн хандив өргөх, сан байгуулах зэрэг нь бүгд иргэдийн идэвх санаачилгын хэлбэрүүд юм. Дунд сургууль, хүүхдийн өдөр өнжүүлэхэд, эцэг эхийн санаачилгын байгууллагууд, биеийн тамир, хөгжмийн нийгэмлэг, соёлын арга хэмжээ, залуучууд, ахмадын байгууллагууд, эмнэлэг, асаргаа сувилгааны байгууллагууд, залуучуудын байгууллагууд, иргэдийн холбоод, хотын дүүргүүд болон орон нутгийн санаачилга, байгаль орчны төслүүд, гал команд, Германы улаан загалмайн нийгэмлэг, орон нутгийн сүм хийдийн зөвлөл, үйлдвэрчний эвлэл, намуудад хаа сайгүй Германы 23 сая гаруй иргэд өөрсдийн идэвх санаачлагаар ажиллаж байна.

II. Германы хүүхэд залуучуудын идэвх санаачлага

- **Хүүхэд залуучууд урьдын адилаар нийгмийн хамгийн идэвхтэй бүлэг хэвээр байна.** Тэд биеийн тамир, хөгжим, сургуулийн болон сургуулиас гадуурх арга хэмжээнүүд, сүмийн болон залуучуудын бүлгийн үйл ажиллагаанд оролцож байна.
- Ахимаг болон дундаж насны иргэд одоогийнхоос илүү идэвх санаачлагатай байсан **1999-аас 2009 онд үед хүүхэд залуучуудын сайн дурын идэвх санаачлага ялимгүй буурах хандлагатай байсан.**
- **Хэдийгээр хүүхэд залуучууд сайн дурын идэвх санаачлагадаа бага цаг зарцуулдаг боловч,** тэдний бүх амьдралын туршид удаан хугацаанд дурсагдах сэтгэл хөдөлгөсөн дурсамж болон үлддэг.
- **Цагийн хомсдол улам ихсэж байгаа нь** хүүхэд залуучуудын идэвх санаачлага буурах шалтгаан болж байна. Өдөр өнжүүлэхтэй сургууль, сургууль ба их дээд сургуульд сурах хугацааг богиносгох зэрэг нь ялангуяа гимнази болон их, дээд сургуульд суралцагчдыг цагийн дарамтанд оруулдаг байна.
- **Хүүхэд залуучуудын тодорхой бүлгүүд сайн дурын идэвх санаачлагын ажилд маш бага оролцож байна.** Нэн ялангуяа **боловсролын түвшин доогуур** хүүхэд залуучуудын идэвх санаачилга улам буурч байна. Тэд хэдийгээр идэвх санаачлага гаргаснаараа сурах боломжоо нэмэгдүүлэх боломжтой боловч тэдний тоо улам цөөрсөөр байна.
- **Цагаач гаралтай хүүхэд залуучуудын идэвх санаачилга** урьдын адил герман хүүхэд залуучуудтай харьцуулахад туйлын доогуур, иргэний нийгмийн байгууллагуудтай харилцаа муутай хэвээр байна. Иргэний нийгмийн байгууллагуудтай холбоотой байдаг бол тэдний иргэний идэвх санаачилгын үйл ажиллагаанд оролцох эрмэлзэл өндөртэй байгаа нь харагдаж байна.
- **20-оос дээш насны залуу эмэгтэйчүүд** сайн дурын идэвх санаачлагад **хойрго ханддаг** нь тэд гэр бүлтэй болохоосоо өмнө ажил мэргэжилдээ илүү анхаарч, ажлаа гэх үү, гэр бүлээ гэх үү гэдэг асуудалд тулгарахаас өөрийгөө бэлтгэж эхэлдэгтэй нь холбоотой.
- **Тодорхой бүс нутагт тогтвортой оршин суух иргэдийн тоо буурч, орон нутгийн холбоос үгүй болж байгаа нь** хүүхэд залуучуудын идэвх санаачлагад **муугаар нөлөөлж байна.** Энэ нь тогтвор суурьшилгүй болгож цаашилбал сайн дурын идэвх санаачлагад ч сөрөг нөлөөтэй.
- Хэдийгээр сөргөөр нөлөөлөх хүчин зүйлүүд их байгаа боловч хүүхэд залуучуудын сайн дурын идэвх санаачлаганд ноцтой хохирол учраагүй байна. **Тодорхой хэсгийн идэвх санаачлага буурсныг бусад хэсгүүдийн илүү идэвхтэй байдал нөхсөн байдалтай байна.** Хүүхэд залуучууд сайн дурын идэвх санаачлагын үйл ажиллагаанд оролцоход зарчмын хувьд бэлэн хэвээр байна. Тэр ч байтугай бэлэн байдал нь улам нэмэгдсэн байна.

14-24 насны хүүхэд залуучуудын сайн дурын идэвх санаачилга, оролцооны байдал, оролцож буй салбарууд

Хэлбэр	Идэвхтэй гишүүд	Байгууллагад үүрэг хүлээж буй болон үүрэг хүлээж буй оролцогчид
Биеийн тамир, хөдөлгөөн	53%	12%
Чөлөөт цаг, цагаа хамтдаа өнгөрүүлэх	25%	3%
Сургууль, цэцэрлэг	14%	6%
Сүм ба шашин шүтлэг	16%	7%
Соёл ба хөгжим	20%	5%
Сайн дурын гал команд, аврах албанд	8%	4%
Залуучууд ба боловсрол	10%	4%
Нийгмийн салбар	8%	3%
Хүрээлэн буй орчин, байгаль ба амьтан хамгаалалт	8%	2%
Улс төр	4%	2%
Иргэний идэвх санаачилгын байгууллагууд	3%	1%
Эрүүл мэнд	4%	1%
Мэргэжлийн ашиг сонирхлыг хамгаалагчид	4%	1%

(Эх сурвалж: „Залуучууд ба иргэний нийгэм“ сэдэвт Бертелсманы судалгаа; тоо баримтууд: Пикот – Нийгмийн шинжлэх ухааны төслүүд ба ТНС Инфратест нийгмийн судалгаа, 2009 он)

III. Иргэний идэвх санаачлагын онцгой хэлбэрүүд: Сайн дурын алба

„Сайн дурын алба“ гэдэг ойлголтонд олон янзын арга хэмжээнүүд багтдаг. Сайн дурын албуудын хооронд дэмжлэг, эрхзүйн хамгаалал, үйл ажиллгааны хүрээ зэрэг олон тодорхой ялгаа бий. Сайн дурын албаны элсэж орох зарчим, тодорхойлолтонд байдаг нэгдмэл зүйл бол сайн дурын алба нь нийгмийн сайн сайхан, оролцогсдын хувийн боловсролд нэгэн зэрэг нэмэр болж, соёлын солилцоо, нэгдмэл байдлыг дэмждэг үйл ажиллагаанд оролцох зэрэг шаардлага юм. Харин сайн дурын үйл ажиллагаагаар ажлын байрыг орлуулж болохгүй.

ГСДН засгийн эрхэнд байх хугацаандаа сайн дурын албыг дэмжих, бэхжүүлэх хуулийн заалт, үндсэн нөхцөлүүдийг улам сайжруулсан. Жишээлбэл: 2002 оноос эхлэн сайн дурын алба хаах хугацааг 6 сар болгон сунгасан. 2008 онд хууль тогтоогч байгууллага НСДНЖ/FSJ (нийгмийн сайн дурын нэг жил) ЭСДНЖ/FÖJ (экологийн сайн дурын нэг жил) гэх хоёр албаны тухай хуулиудыг нэгтгэн хууль эрх зүйн үндэслэлийг илүү ойлгомжтой болгожээ.

Залуучуудын сайн дурын алба

Залуус сайн дурын албыг эх орондоо болон гадаадад хааж болно. 15-аас 27 насны сайн дурын алба хаагчид 6-аас 24 сар хүртэл нийтийн эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд болох эмнэлэг, хүүхдийн өдөр өнжүүлэхээс эхлээд байгаль хамгааллын станц, соёлын байгууллагуудад орон тооны, мэргэжлийн ажилтнуудад туслан ажилладаг. Сайн дурынхан орон тооны ажлын байрыг орлох ёсгүй бөгөөд заавал хаах ба иргэний албанаас (Pflicht- und Zivildienst) эрс ялгаатай. Сайн дурын үндсэн дээр алба хаах зарчим нь залуучуудын сайн дурын албуудын гол онцлог шинж юм. 2010 онд ойролцоогоор 25.000 хүүхэд залуучууд сайн дурын албыг хаажээ.

Холбооны сайн дурын алба

Цэргийн албыг орлох иргэний албыг үгүй болгосны дараагаар түүнийг орлох холбооны сайн дурын албыг сайн дурын албаны нэгэн хэлбэр болгон хөгжүүлсэн. /Холбооны гэр бүл, ахмадууд, эмэгтэйчүүд, залуучуудын яамнаас/ 27-гоос дээш насныханд илүү сонирхолтой (долоо хоногт 20-оос доошгүй цагтай) байж болох өөр нэг сайн дурын албыг байгуулсан юм.

Нийгмийн сайн дурын нэг жилийн алба (НСДНЖА / FSJ), Экологийн сайн дурын нэг жилийн алба (ЭСДНЖА / FÖJ)

Сайн дурын албаны ихэнх нь Нийгмийн сайн дурын нэг жилийн алба (НСДНЖА) ба Экологийн сайн дурын нэг жилийн алба (ЭСДНЖА)*-ны хэлбэрээр хүүхэд залуучуудад хандсан байдаг. НСДНЖА ба ЭСДНЖА нь заавал хаах ёстой алба биш бөгөөд өөр өөр боловсролын түвшинтэй хүүхэд залуучуудад мэргэжлийн чиг бараимжаагаа олоход нь туслах зорилготой юм. Залуучуудын сайн дурын алба хүүхэд наснаас залуу насанд шилжих шилжилтийн үед нь хувь хүн болон төлөвших, мэргэжлийн чиг баримжаагаа олоход нь тусалдаг. Сайн дурын албыг хааснаараа суралцах туршлага хуримтлуулж мэргэжлийн, нийгмийн, олон талт соёлд дасан зохицох ур чадварыг эзэмшдэг. Албан бус боловсролыг тодорхой нийгмийн хариуцлагатай уялдуулснаар сайн дурын алба нь олон арван жилийн туршид дунд сургууль ба мэргэжлийн сургалтыг холбох чухал талбар болсон юм. Эдгээр шалтгааны улмаас НСДНЖА ба ЭСДНЖА болон бусад хэлбэрийг холбооноос байнга дэмжиж ирлээ.